

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН
ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар 2022

ГАРЧИГ

НЭГ. УДИРТГАЛ

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ҮҮРЭГ, ЗАРДАЛ

- 2.1.Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтыг тодорхойлсон нь
- 2.2. Хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоолол

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ИРГЭНД ҮҮСЭХ ҮҮРЭГ, ЗАРДАЛ

- 3.1.Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтыг тодорхойлсон нь
- 3.2. Иргэнд үүсэх зардлын тооцоолол

ДӨРӨВ.ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ҮҮРЭГ, ЗАРДАЛ

- 4.1.Төрийн байгууллагын үүрэг хүлээсэн заалтыг тодорхойлсон нь
- 4.2. Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоолол

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

НЭГ.УДИРТГАЛ

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалттай уялдан Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу судлав.

Тус судалгаа, тооцооллын зорилго нь хуулийн төсөл батлагдсанаар үүсэх харилцааг хэрэгжүүлэхэд холбогдох иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг урьдчилан магадалж тооцоолох, санал, дүгнэлт боловсруулахад чиглэгдсэн болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу энэ хуулийн төсөлд хамаарах хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллага гэсэн субъектын хүрээнд алхам тус бүрт мэдээлэл цуглуулж, стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэн тооцооллыг хийсэн. Үүнд:

1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох;
2. Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох;
3. Төрийн байгууллагад үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох;
4. Субъект тус бүрээр гарах зардлыг тооцоолох;
5. Тоон үзүүлэлтүүдийг тооцох;
6. Зардлын дүнг тооцон гаргах;
7. Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах;
8. Нэмэлт зардал тооцох.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг тооцоход дор дурьдсан нийтлэг зарчмыг баримталсан. Үүнд:

1. Гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
2. Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодьтой хандах;
3. Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
4. Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

ХОЁР. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Энэ хэсэгт Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээд тодорхой төрлийн үүрэг гүйцэтгэхийг даалгасан буюу шаардсан бол үүний дагуу хуулийн этгээдэд үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана.

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

1. Хуулийн тэгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. Нэг бүрийн зардлыг тооцох;
3. Тоон үзүүлэлтийг тооцох;
4. Нийт зардлын дүнг тооцож гаргах;
5. Хялбарчлах боломжийг шалгах;
6. Нэмэлт зардлыг тооцох.

Нэгдүгээр үе шатны хүрээнд: Хуулийн этгээдэд шинээр үүрэг үүсгээгүй байна.

Иймд аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсхийг уг хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд зардал үүсгэхгүй байна.

ГУРАВ. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо дараах үе шатыг баримтална. Үүнд:

1. Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
3. Тоон үзүүлэлтийг тооцох;
4. Нийт дүнг тооцож гаргах;
5. Хялбарчлах боломжийг шалгах.

Нэгдүгээр үе шатны хүрээнд: Энэ хэсэгт хуулийн төслийг судлан хуулийн төслөөр иргэнд тодорхой үүрэг гүйцэтгэхийг даалгасан эсэхийг тогтоож, гарах зардлыг тооцно.

Хуулийн төслөөр иргэдэд шинээр үүрэг үүсгээгүй тул зардал үүсгэх зохицуулалт байхгүй байна.

Иймд аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй гэж үзэв.

ДӨРӨВ. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ТӨРД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцоолохдоо доорх дарааллыг баримтална. Үүнд:

1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. Уг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
3. Гарах зардлыг тодорхойлох;
4. Зардлын төрлүүдийг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Нэгдүгээр үе шатны хүрээнд:

Төрийн байгууллагад шинээр үүрэг үүсгээгүй байх тул цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд хуулийн төслөөр төрд үйл ажиллагааны нэмэлт зардал үүсэх эсэхийг дараагийн шатанд шалгах шаардлагагүй байна.

ТАВ.ДҮГНЭЛТ

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баримтлан тооцоолов.

Хуулийн төслийг судлан үзэхэд шинээр зардал үүсгэх зохицуулалт агуулагдаагүй хэдий ч нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэмжээг өргөн хэрэглээний бараа, ажил, үйлчилгээнд нэмэгдүүлснээр урьдчилсан байдлаар 200 орчим тэрбум төгрөгийн буцаан олголтыг иргэдэд олгох тооцоо гарч байна. Нөгөөтэйгүүр далд эдийн засгийг хумих, татварын тэгш шударга орчныг бий болгосноор улсын төсвийн орлого нэмэгдэх боломжтой тул улсад учрах дарамт бага байх боломжтой юм.

Иймд уг хуулийн төсөл нь урт хугацаанд улсын төсөвт үүсгэх ачаалал бага байх боломжтой байгааг анхаалдаа авах нь зүйтэй.

--- оОо ---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Хууль тогтоомжийн тухай хууль;
2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
3. Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоол;

---oOo---

² Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 01/дугаар албан бичгийн 1 дүгээр хавсарлт.

³ Мөн албан бичгийн 2 дугаар хавсарлт.

⁴ Мөн албан бичгийн 3 дугаар хавсарлт.